

Дархан сумын 13-р багийн 2017 онд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд” хийсэн ажлын тайлан


Хөршийн холбоо эргүүлийг 3 дахь жилдээ тогтмол зохион байгуулж байна.

Зорилго нь иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болоход оршино.

Хөршийн холбоо эргүүлийг 7 удаа зохион байгуулж ажиллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагаан-Өргөө, Ялалт СӨХ-дын байруудын орцны гэрэл гаднах зам талбайн гэрэлтүүлэг, хаалга үүдний бүрэн бүтэн байдлыг шалгаж ажиллав. Уранчимэг захиралтай Цагаан-Өргөө СӨХ-ны 22,23,24,30,31-р байрнуудын орцны гэрэл асаастай, хаалга үүд бүрэн бүтэн, Ялалт СӨХ-ны 25,26,27,28,32-р байрнуудын зарим орц гэрэлгүй, зарим хаалга нь хаагддаггүй гэх мэт зөрчил илэрсэн.

Ялалт СӨХ-ны гүйцэтгэх захирал М.Ганхуягт зөрчлийг арилгах талаар үүрэг өгөв.



Багийн Захиргаа, ИНХ-тай хамтран байр
түрээслэдэг өрх болон оюутнуудад санамж,
зөвлөмж хүргүүлж ажиллаж байна.

Энэхүү уриалгыг бид 22,23,24,30,31-р байранд
түрээсээр оршин суудаг 29 оюутанд биечлэн хүргэж
зөвлөлгөө өгч ажиллаа.

* Уриалга

Дархан хотын ухаалаг, хариуцлагатай, идэвхитэй иргэн байхын тулд Та бүхнийг уриалан доорхи зорилтуудыг дэвшүүлж байна.

1. Орон сууцныхаа орцонд хогоо хаяхгүй байх
2. Хаягдал хогоо хогийн төвлөрсөн саванд хийж байх
3. Нийтийн эзэмшлийн тоглоом, сүүдрэвч, сандал зэргийг хайр гамтай ашиглаж байх
4. Орон сууцныхаа орчинд мод, бут, сөөг зүлэг тарьж ургуулдаг байх
5. СӨХ-ны төлбөрөө сар бүр тушаадаг байх
6. Нийтийг хамарсан их цэвэрлэгээ, тохижилтын ажилд иргэн бүр санаачлагатай оролцдог байх
7. Орон сууцандаа хийн баллон ашиглахгүй байх
8. Орц, байрны орчинд согтууруулах ундаа, тамхи хэрэглэхгүй байх

Уриалга дэвшүүлсэн:

Дархан сумын 13-р багийн
ИНХ-ын тэргүүлэгчид


Дархан сумын 13-р багийн
Захиргаа

Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Алтантуяа
Сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Нямбаяр

Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон ААНБ-уудыг “Нийтийн эргүүл”-дээ хамруулан хамтарч эргүүл хийлээ.

* Багийн Засаг дарга буюу сумын ИТХ-ын төлөөлөгч Б.Нямбаяр, аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Алтантуяа, багийн зохион байгуулагч Н.Цогзолмаа, нийгмийн ажилтан С.Адъяасүрэн, олон нийтийн цагдаа Б.Гантогтох болон Дархан Нэхий ХК-ны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн гишүүдийн хамт 2016 оны 12-р сарын 06-ны орой багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Ди Ди, Өсөх, S&B, Од гэсэн 4 баарны үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаа.

Зорилго нь: Төрийн болон төрийн бус байгууллагуудыг хулгайн гэмт хэрэг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камер болон гэрэлтүүлэг шаардлагын хэмжээнд байгаа эсэх, мөн 21 нас хүрээгүй иргэнд архисогтууруулах ундаагаар үйлчилж байгаа эсэх, байгууллагын 50м² газрын цас,мөсөө цэвэрлэсэн эсэх тал дээр хяналт тавин ажиллаа.



* Төрийн болон төрийн бус байгууллагуудыг хулгайн гэмт хэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камер, гэрэлтүүлэгийг шаардлагын хэмжээнд хүргэх


Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон ААНБ-уудын хяналтын камер, гэрэлтүүлэг нь шаардлагын хэмжээнд байгаа эсэх тал дээр хяналт тавин ажиллаа.

5 их, дээд, сургууль, коллеж, 3 цэцэрлэг, 1 улсын эмнэлэг, архи согтууруулах ундаа худалдаалдаг болон түүгээр үйлчилдэг 12 аанб, 1 кино театр, 2 банк, 18 үйлдвэр, 1 хүнсний дэлгүүр гэх 43 аанб-ын хяналтын камер, гэрэлтүүлэг шаардлагын хэмжээнд байв. Цаашид хяналтын камер заалшгүй шаардлагатай 24 цагаар ажилладаг 2 эмийн сан, 6 хүнсний дэлгүүр нийт 8 ААНБ-д хяналтын камерын систем холбох үүрэг өгч ажиллаа.

Хөршийн холбоо эргүүлийн баг 1,10,29,30-р хороололд гудамж талбайн эргүүл хийж Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 14 машинд сэрэмжлүүлэг нааж ажиллаа.



Хөршийн холбоо эргүүлийн баг, ДДЦС-ТӨХК-ны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран 1-р хороололд гудамж талбайн эргүүл хийлээ. Мөн УУЭХПТКоллежийн дотуур байрны үйл ажиллагаатай танилцлаа.



Хөршийн холбоо эргүүлийн баг интернет, цахим тоглоомын газруудын үйл ажиллаанд хяналт тавин ажиллаа. Зөрчил гаргасан 1 цахим тоглоомын газрыг Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар тогрох шийтгэл ноогдуулсан.



Согтууруулах ундаа хэрэглэдэг, эрхэлсэн тодорхой ажилгүй, гэмт хэрэг үйлдэж болзошгүй хорих ангиас суллагдсан иргэдийг нийгэмшүүлэн ажиллах талаар

- * Архины байнгын хамааралтай 5 иргэн, сүүлийн саруудад архи ууж зөрчил гаргасан 15 иргэний судалгааг шинэчилэн гаргав.
- * Хорих ангиас суллагдсан иргэн Э-г 2017 оны 2-р сард ХХҮГ-тай хамтран орон гэртэй болгож Дархан Нэхий ХК-д ажилд оруулав.



Багийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч М.Анхболд ХААИС-ийн дотуур байрны оюутнуудад Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулиудыг суртчилж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч ажиллаа.



Хамтарсан багаар ажиллах талаар

Хамтарсан баг-Иргэдийн амьдрал аяны хүрээнд манай багийн хамтарсан баг хурлаа хийж төлөвлөгөө гарган ажиллаж байна. Өргөдөл, гомдол гарсан кейсүүд дээр ажиллаж байна.




Хамтарсан баг-Иргэдийн амьдралд аяны хүрээнд “Хөршийн холбоо эргүүл зохион байгууллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 5 байрны 14 орцонд мөн 15 машинд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг нааж ажиллаа. Мөн гудамж талбайн эргүүл хийв. Од буудлыг шалгаж ажиллаа. Гарсан зөрчилгүй тайван байлаа.



Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг ГБХЗХГ-тай хамтран багийн иргэдэд танилцууллаа. ГБХЗХГ –ын гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Мягмаржаргал сургалт зохион байгууллаа.





ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ
ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР:

- 102 Цагдаагийн шуурхай дуудлага
(Мэдээлэл гурван өнц)
- 107 Улаанбаатар хотын цагдаагийн
гэр бүлийн хүчирхийллийн
мэдээллийн үтэс
(Мэдээлэл гурван өнц, эхлэлтэн өнц)
- 108 Хүүхдийн тусламжийн үтэс
(Мэдээлэл гурван өнц, эхлэлтэн өнц)

Таны үтэс нэгжгүй байсан ч элсэн болсонтой!

www.safefuture.mn
Facebook.com/NationalCenterAgainstViolenceMongolia/

Багийн иргэдийн дунд “Гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар” мэдлэг дээшлүүлэх зорилгоор тэмцээн зохион байгуулж ажиллаа. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиас асуулт, хариултын тэмцээн зохион байгуулахад багийн иргэн Р.Цэрэнхүү, Д.Соль нар шалгарлаа. Хамтарсан багийн гишүүд өөрсдөө мөнгөн хуримтлал цуглуулж шагналын сан үүсгэж тэмцээнд амжилттай оролцсон 2 иргэнг мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.




Сургалт зохион байгуулсаны дараа /Хамтарсан багийн гишүүд/
Дархан сумын 13-р багийн Б.Нямбаяр, нийгмийн ажилтан
С.Адъяасүрэн, ГБХЗХГ-ын мэргэжилтэн А.Мягмаржаргал, Од
цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан Б.Удвал, ГБХЗХГ-ын
мэргэжилтэн П.Сувдмаа, ХХҮГ-ын баг хариуцсан мэргэжилтэн
Д.Хишигсүрэн, Олон нийтийн цагдаа Б.Гантогтох нар оролцлоо.



2017 онд хүүхэд хамгааллын 108 утас болон ГБХЗХГ-т өргөдөл, гомдол ирүүлсэн нийт 5 кейс дээр хамтарсан багаар ажиллаж дүгнэлт гарган холбогдох дээд шатны байгууллагад уламжлан ажиллаа.



“Хамтарсан баг-Иргэдийн амьдаралд” аяны хүрээнд манай хамтарсан баг амжилттай ажиллаж Дархан сумын “Шилдэг хамтарсан баг”-аар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.



2018 ОНД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гаргах
2. Гэр бүлийн өдөрлөг зохион байгуулах /Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль танилцуулах/
3. Хамтарсан багаар ажиллах /өргөдөл, гомдол ирсэн кейсүүд дээр хурдан шуурхай ажиллаж гомдлыг барагдуулж холбогдох дээд шатны байгууллагад уламжилах/
4. Багийн иргэд, ААНБ, болон их, дээд сургууль, коллежийн оюутнуудад хууль сурталчилах ажлыг зохион байгуулна
5. Гэмт хэрэг, зөрчил архидан согтуурахтай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцлийг сайжруулах зорилгоор багийн нутаг дэвсгэрт "Хөршийн холбоо эргүүл"-ийг зохион байгуулна.

6. Согтууруулах ундаа хэрэглэдэг, эрхэлсэн тодорхой ажилгүй, гэмт хэрэг үйлдэж болзошгүй залуучуудыг нийгэмшүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

7. Багийн Захиргаа, ИНХ-тай хамтран байр түрээслэдэг өрх болон оюутнуудад санамж, зөвлөмж хүргүүлж ажиллана

8. Багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг томоохон ААНБ-уудыг "Нийтийн эргүүл"-дээ хамруулан хамтарч эргүүл зохион байгуулна

9. Гэр хорооллын айл өрхүүдийн гудамжны хаягжилт, тохижилтын ажлыг зохион байгуулах, гэрэлтүүлэг, камерын систем холбох ажлыг зохион байгуулах

10. Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагуудыг хулгайн гэмт хэрэг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камер гэрэлтүүлэгийг шаардлагын хэмжээнд хүргэх

11. Зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар багийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилах

12. "Оюутан цагдаа" эргүүлийн үйл ажиллагааг сайжруулж их, дээд сургуулийн хичээлийн байр болон дотуур байр орчимд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллуулах

13. Орон сууцны 1-р давхарт үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдийн архины зөвшөөрлийг цуцлах

14. Олон нийтрүү чиглэсэн шинэлэг ажил болон төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ажлын тайланг сумын ЗДТГ-т хүргүүлэх

2018 ОНЫ 1-Р
УЛИРАЛД ХИЙСЭН
АЖЛУУД

Хамтарсан багаар ажиллах болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гаргав.



Урамшуулалт эргүүл 3 удаа зохион байгуулан ажиллаа.



2018 онд Иргэдийн идэвхи оролцоог
нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх мэдлэг, мэдээлэлтэй болоход
зорилго тавин ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа